

Төслийн нэр: “Хүүхэд-гэр бүл хөгжлийн өргөө” ажиллуулах

Хэсэг I: Төсөл санаачлагчийн мэдээлэл

Аймаг/ хот: Архангай
Сум /дүүрэг: Батцэнгэл сум
Сургууль, СЭЭБХ-ны хаяг: Архангай Батцэнгэл сум ЕБС
СЭЭБХ-ны зохицуулагчийн овог, нэр: Б.Алтанчимэг

Хэсэг IIa. Нөхцөл байдлын шинжилгээ

Дотоод хүчин зүйлс	
Давуу тал 1. СЭЭБХ нь тамга тэмдэг, гэрчилгээгээ авсан. 2. Эцэг эх, сургуулийн удирдлагууд тодорхой хэмжээний ойлголттой. 3. Бага ангийн багш нарын ур чадвар сайн.	Сул тал 1. Эцэг эхийн оролцоо муу. 2. СЭЭБХ-ны үйл ажиллагаа тогтмол биш. 3. Үйл ажиллагаа явуулах өрөө байхгүй. 4. Сурагчдын ихэнх нь эмээ өвөө дээрээ байдаг.
Гадаад хүчин зүйлс	
Боломж 1. СЭЭБХ-ны үйл ажиллагааг тогтмолжуулах 2. Сурлагын чанар сайжирна. 3. Эцэг эхийн оролцоо нэмэгдэнэ.	Эрсдэл 1. Сургуульд сул өрөө танхим байхгүй. 2. Сурагчид эмээ өвөө дээрээ байдаг болохоор гэрийн даалгавараа хийхгүй ирэх нь элбэг тул сурлагын амжилт сайн биш.

Хэсэг IIб. Төслийн зорилго, хамрах хүрээ

Зорилго	Сургуулийн эцэг эх, багшийн холбооны үйл ажиллагааны шинэлэг загварыг турших замаар холбоог хүчирхэгжүүлж, эцэг эхийн оролцоог нэмэгдүүлнэ.
Хамрагдах хүний тоо	Бага боловсролын 256 сурагч, 10 багш, СЭЭБХ, сургуулийн удирдлагын баг

Хэсэг III. Төслийг хэрэгжүүлэх зохион байгуулалт ба ажлын төлөвлөгөө

№	Үйл ажиллагаа	Хариуцах эзэн	Хугацаа	Хүрэх үр дүн
1.	Төслийн нээлтийн үйл ажиллагаа	СЭЭБХ-ны УЗ	2019.9-р сард	Төслийн зорилго, зохион байгуулах үйл ажиллагаа, ач холбогдлыг танилцуулна.
СЭЭБХ-ны Зохицуулагч, Удирдах зөвлөлийг чадавхжуулах хүрээнд				
2.	“Хүүхэд-гэр бүлийн хөгжлийн өргөө” тохижуулах	СЭЭБХ-ны гишүүд,	2019.6-7-р сар	Сургуульд “Хүүхэд-гэр бүл хөгжлийн өргөө” байгуулан, эцэг эхчүүд багш нартай тогтмол уулзаж, ярилцах, сургуульд туслах ажилд эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх боломж бүрдэнэ.
3.	Хүүхдийн эрх, хамгаалал, хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг	Хүүхдийг ивээх сангийн “Хүүхэд хамгааллын арга зүйн	2019.9-р сарын 24-27	СЭЭБХ-ны Зохицуулагч, Удирдах зөвлөлийн гишүүд болон СЭЭБХ-ны үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог төрийн албан хаагч эцэг эхчүүдийн төлөөллийг энэ туршлага судлах аялалд

	байгууллагуудаас туршлага судлах	төв”, Чингэлтэй дүүргийн Гэр бүл, хүүхэд хөгжлийн төв, Хүүхдийн төлөө үндэсний газар, “Хүүхэд, өсвөр үе” төв		хамруулна. УБ хотод үйл ажиллагаа явуулж буй төрийн болон ТББ-аас туршлага судлах, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх зорилготой СЭЭБХ-ны алдаа оноог олж харах, цаашид үйл ажиллагаандаа санаа авч хэрэгжүүлнэ.
4.	Туршлага судлах аялалд оролцогчид төлөвлөгөө боловсруулах	СЭЭБХ-ны төлөөллүүд	2019.10-р сар	Сургагч багшийн сургалт болон туршлага судлах аяллын хүрээнд сурсан зүйлээ өөрийн орон нутаг, эцэг эхчүүдэд хэрхэн түгээх, СЭЭБХ цаашид хэрхэн ажиллах талаар урт хугацааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ.
Эцэг эхийн оролцооны туршлагыг түгээн дэлгэрүүлэх хүрээнд				
5.	Судалсан мэдлэг, ойлголт, туршлагаа хуваалцах уулзалт зохион байгуулах	СЭЭБХ-ны төлөөллүүд	2019.10-р сар	СЭЭБХ-ны гишүүдийн чадавх сайжирч, бусад эцэг эхийн оролцоо нэмэгдэнэ.
6.	“Номын цаг” хөтөлбөр	СЭЭБХ, багш, эцэг эх	2019.9-р сараас тогтмол хуваарь гаргана	Хүүхэд-гэр бүл хөгжлийн өргөөнд эцэг эхчүүдэд зориулсан номын булан байгуулж, эцэг эхчүүд хүүхэдтэйгээ хамтран уншлага хийдэг цагтай болж, сурагчдын унших чадварыг нэмэгдүүлэхэд эцэг эхийн оролцоог шинээр бий болгоно.
7.	“Номтой цаг” хэлэлцүүлэг	СЭЭБХ, багш, эцэг эх	2019.9-р сараас сар бүр	Эцэг эхчүүдийн дунд уншсан номын сэдэв бүрээр хэлэлцүүлэг өрнүүлдэг болно. Тогтмол зохион байгуулж, эцэг эхчүүдийн хүсэн хүлээдэг, тогтмол оролцдог үйл ажиллагаа болгоно.
Сурлагын амжилтыг дээшлүүлэх хүрээнд				
8.	Хамтдаа бүтээцгээе! хөтөлбөр, тоглоомын сан байгуулах ажлын төлөвлөгөө боловсруулах	СЭЭБХ-ны УЗ, сургуулийн удирдлагууд тай хамтарна	2019.9-р сард	Үйл ажиллагаа тус бүрээр хөтөлбөр, төлөвлөгөө гаргаж, хариуцах багуудыг бүрдүүлж ажиллана. Сургалтын менежер, нийгмийн ажилтантай хамтран хөтөлбөр, төлөвлөгөө гаргаж захирлаар хянуулж батлуулна.

9.	Хамтдаа бүтээцгээе! Хөтөлбөр: гэрийн нөхцөлд хүүхдээ хөгжүүлэх	СЭЭБХ, багш, эцэг эх	2019.10-р сараас	Бага ангийн эцэг эх, багш нар сургалтад ашиглах боломжтой тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүнийг өөрсдөө бүтээнэ. Багш, эцэг эхийн хамтын үйл ажиллагаа сайжирна.
10.	Тоглоомын сан	СЭЭБХ, багш, эцэг эх	2, 3-р улиралд	Тоглоомын сан эцэг эхийн оролцоотой бүтээж, хэрэглэгдэхүүнээ анги бүрээр аялууулж ашиглана.
11.	Үр дүнгийн тайлан	СЭЭБХ	2020.4-р сар	Төслийн хугацаанд хийсэн үйл ажиллагааг тайлагнах, цаашид Хүүхэд-гэр бүл хөгжлийн өрөөг идэвхтэй, үр дүнтэй ажиллуулах төлөвлөлтөд санал, хүсэлт авна.

“Хүүхэд-гэр бүлийн өрөө”-нд эцэг эхчүүдийн хийх тоглоом, хичээлийн хэрэглэгдэхүүний загвар:





Tykes N Tots Dayhome

Хэсэг IV Зардлын задаргаа

Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ, төг	Нийт үнэ, төг	Тус бүрт нь хүрэх үр дүнг бичнэ. (Хүүхдэд ямар бодит үр дүн авчрах, ямар чадварыг эзэмшүүлэх)
Төслийн нээлтийн үйл ажиллагааны зардал Баннер/Стэнд	ш	2	50,000	154,000 100,000	Сумын удирдлагууд, эцэг эх, багш нарыг нээлтийн үйл ажиллагаанд урьж, СЭЭБХ-ны үйл ажиллагаа ач холбогдлыг танилцуулахаас гадна төслийн хүрээнд зохион байгуулах үйл ажиллагааг танилцуулна.
Хүүхэд-гэр бүл хөгжлийн өргөөг тохижуулах • Өнгөт принтер • Ламинатор	ш ш	1 1	500 000₮ 120 000₮	500 000₮ 120 000₮	Ном, гарын авлага дутмаг тул өнгөтөөр олшруулах шаардлагатай тул А-4 хэвлэдэг принтер авснаар өөрсдөө хүүхэд бүрт гарын авлага, тараах материал хэвлэж өгөхөд худалдаж авснаас бага зардал гарна. СЭЭБХ-ны талаар эцэг эх болон багш нар мэдээллийн самбараас тухай тухай үеийн мэдээллийг харах боломжтой.
Туршлага судлах аяллын зардал	Удаа	1		945 000₮	УБ хотод байрлах, унаа болон бусад зардал

Туршлага судлах аяллын унааны зардал	2 талд	1	60,000*5	300,000	Унааны зардал
Туршлага судлах аяллын томилолтын зардал	хоног	4	30 000*5нэг хүнд	600,000	Томилолтын зардал
СЭЭБХ-ны гишүүд өөрийн орон нутгийн эцэг эхчүүдэд сургалт зохион байгуулна.	удаа	2	100,000	200,000	Сургалт зохион байгуулах зардал
“Номтой цаг” хэлэлцүүлэг	Удаа	5	150,000	750,000	Хэлэлцүүлгийн үр дүнд эцэг эх, багш нар бие биедээ уншсан номын агуулгын талаар танилцуулж, ном унших сонирхол, сэдлийг төрүүлнэ. Эцэг эх хүүхдээ хүмүүжүүлэх зэрэг ном уншсанаар хүүхдээ хүмүүжүүлэх мэдлэг, ойлголт нэмэгдэж, хүүхдийн хүмүүжил, сурлагын амжилтад сайнаар нөлөөлнө.
Номын худалдан авалт	ш	30	10,000	300,000	Эцэг эхчүүдэд зориулсан ном
Бичиг хэрэг					
Бичгийн цаас	боодол	3	50,000	150,000	Тоглоом, хэрэглэгдэхүүнийг эцэг эх өөрсдийн гараар хийхэд хэрэглэгдэх зүйлс. Нэг удаа хэрэглэх биш цаашдаа дараа дараагийн ангиудад хийсэн бүтээсэн хэрэглэгдэхүүнийг хүлээлгэж өгөх. Хүүхэд бүрт гарын авлагаа хэвлэж өгөхөд худалдаж авснаас бага зардал гарна.
Ламинаторын цаас	Боодол	6	20,000	120,000	
Өнгөт хор	ш	2	50,000	100,000	
Өнгийн цаас	боодол	6	6,000	36,000	
Фото цаас (том)	боодол	6	30,000	180,000	
Фото цаас (жижиг)	боодол	6	15,000	90,000	
Флосмастер, бусад				111,000	
Харилцаа холбооны зардал		6	15000	60,000	Утасны нэгжний зардал
Интернэтийн зардал	сар	8	15,000	120,000	Мэйл, мэдээлэл, тайлан, баримтжуулалт хүргүүлэх
Үйл ажиллагааны зардал	удаа	10	30,000	300,000	Үйл ажиллагааны бэлтгэл уулзалтын зардал
Банкны шилжүүлэг				50,000	
Бүгд					5286000₮

Хэсэг VI Төслийн тогтвортой байдал

Төслийн үйл ажиллагаа нь: СЭЭБХ-ныөөрийн гэсэн өрөө танимтай болсноор бага ангийн сурагчдын сурлагыг чанар сайжрахад эцэг эхийн оролцоог нэмэгдүүлнэ.

Төслийн тогтвортой байдлыг хангахад чухал зүйлс нь:

- Хүүхэд бүр бие даан бүтээлчээр суралцах хүсэл эрмэлзэлтэй болно.
- Багшийн заах арга зүй, мэдлэг мэргэжлийн түвшин дээшилсэн учир цаашид сургалтыг үр дүнтэй зохион байгуулах боломж бүрдэнэ.
- Сайн дурын бүлгийн дэмжлэг нөлөөллийн ажлаар эцэг эхийн идэвх оролцоог өргөжүүлж, хүүхдийн сурч хөгжих таатай орчин нөхцөл бүрдэнэ.
- Үйл ажиллагааг уламжлал болгон тогтвортой үргэлжлүүлэн ажиллана.